



БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

АГТ-20/09-28/16

Энэхүү гэрээг Барилгын тухай, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон:

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК, түүнийг төлөөлж Хяналт шалгалтын газрын дарга М.Амарсайхан (цаашид “Захиалагч буюу “МТЗ” ТӨХК гэх);

Зэвсэгт хүчний 110 дугаар анги, түүнийг төлөөлж Ерөнхий инженер, хошууч Л.Баттулга (цаашид “Гүйцэтгэгч” гэх);

нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) Гүйцэтгэх ажил, хугацаа, ажлын үнэ, хөлсний хэмжээг харилцан тохиролцож дараах нөхцлөөр байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Гэрээний зорилго нь Гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлыг тохиролцсон хугацаанд хийж гүйцэтгэх, Захиалагч тал нь үнэ, ажлын хөлсийг гэрээнд заасны дагуу төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах, Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага болон тэдгээртэй холбогдсон бусад харилцааг тодорхойлох, зохицуулахад оршино.

1.2 Ажил гүйцэтгэх гэрээний зүйл нь Дорноговь аймаг дахь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын 5 дугаар зөрлөгийн Барилга байгууламжийн нэр заасан ажил байх ба энэ нь ажлын үр дүн болно.

1.3 Гүйцэтгэгч талын гэрээний үүргийн хэрэгжилтэд Зэвсэгт хүчний бүтээн байгуулалт, дэмжлэгийн газар хяналт тавьж, удирдлага, арга, зүйгээр хангана.

1.4 Шинээр барих барилга байгууламжид дараах барилга угсралтын ажил балтана.
Үүнд:

- 1.4.1 Удирдлагын байр;
- 1.4.2 Орон сууцны барилга;
- 1.4.3 Гадна цэвэр бохир усны шугам, цэвэрлэх байгууламж;
- 1.4.4 Зам, талбайн тохижилтийн ажил.

1.5 Барилгын ажил гүйцэтгэхдээ үр ашигтай техник, технологийг сонгон ажиллах ба барилгын ажил гүйцэтгэх хугацааг богиносгож, барилгын чанарыг зураг төсөл, барилгын норм, дүрэмд заасан нормативт хэмжээнээс бууруулалгүй, төлөвлөсөн санхүүжилтэд багтаах, нөөц бололцоог ашиглах, хэмнэлтийн зарчмыг баримтлан ажиллана.

1.6 Барилгын ажлын зураг төсөл, ажлын тоо, хэмжээ, ажлын хуваарь, хугацаа, ажлын төсвийг Талууд харилцан тохиролцож, зөвшөөрсөн байна.

1.7 Гэрээний энэ зүйлд заасан бичиг баримт нь гэрээний хавсралт байх ба энэ нь Гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр, түүний салшгүй хэсэг байна. Үүнд:

- Хавсралт-1: Зураг төсөл, ажлын зураг, ажлын тоо хэмжээ;
- Хавсралт-2: Барилга угсралтын ажлын төсөв;
- Хавсралт-3: Барилга угсралтын ажлын календарчилсан төлөвлөгөө;
- Хавсралт-4: Тусгай зөвшөөрөл;
- Хавсралт-5: Барилгын ажил гүйцэтгэх талбайн зохион байгуулалтын төлөвлөгөө.

1.8 Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гэрээнд заагаагүй, урьдчилан төлөвлөх боломжгүй бусад асуудал, харилцаа үссэн тохиолдолд Монгол Улсын Хууль тогтоомж, олон улсын болон үндэсний стандарт, барилгын норм ба дурэм, журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

1.9 Барилгын үйл ажиллагаат Барилгын тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөл, барилгын ажлын зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэнэ.

1.10 Энэхүү гэрээний хэрэгжилтэд Төсөл, хөрөнгө оруулалтын хэлтэс, Төслийн нэгж, Хяналт шалгалтын газар хяналт тавьж, ажлын гүйцэтгэлийг тайлагнана.

Хоёр. Гэрээний хугацаа

2.1 Гүйцэтгэгч барилга угсралтын ажлыг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эхэлж, 2020 оны 08 дугаар сарын 01-ний дотор дуусгаж хүлээлгэн өгнө.

2.2 Гүйцэтгэсэн ажлыг гэрээний Хавсралт З-т заасан ажил гүйцэтгэх хуваарь, хугацааны дотор МТЗ-д тухай бүр хүлээлгэн өгнө.

2.3 Талууд гэрээний хугацааг харилцан тохиролцсоноор бичгээр үйлдэн сунгаж болно.

2.4 Давагдашгүй хүчин зүйл тохиолдсон бол ийнхүү давагдашгүй хүчин зүйл үргэлжилсэн хугацаагаар ажил гүйцэтгэх хугацааг сунгасанд тооцно.

2.5 Давагдашгүй хүчин зүйлээс бусад тухайлбал, ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, ажил гүйцэтгэхэд шаардагдах техник тоног төхөөрөмжийг тээвэрлэхэд гарсан аливаа saat, эрсдэл, санхүүгийн хүндрэл, энэ гэрээнд заасны дагуу ажлын гүйцэтгэлийн доголдлыг арилгасан зэрэг нь ажил гүйцэтгэх хугацааг өөрчлөх, хойшлуулах үндэслэл болохгүй.

2.6 Ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, эсхүл хугацаа хожимдуулж гүйцэтгэсэн нь Захиалагчийн зүгээс Гүйцэтгэгчид Иргэний хуульд заасан алданги болон торгууль ногдуулах үндэслэл болно.

Гурав. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл

3.1 Энэхүү гэрээгээр гүйцэтгэх ажлын төсөвт өртөг нь Барилга угсралтын ажлын төсөвт заасан **1 554 475 810** төгрөг байна.

3.2 Гэрээний үнэ, төсөв, үнийн задаргааг хавсралт-2-д заасан ба үнэ, хөлсөнд цалин хөлс, үндсэн ажлын зардал, бараа, материал, техник, тээвэр, холбогдох бусад зардал бүгд багтсан болно.

3.3 Гэрээний үйлчлэх хугацаанд гэрээний үнэ өөрчлөгдөхгүй ба үнэ, төлбөрийг Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөгөөр гүйцэтгэнэ.

3.4 Гэрээний 3.1-д зааснаар гэрээний ажлын төлбөрийг дараах байдлаар шилжүүлнэ. Үүнд:
а) урьдчилгаа ажлын төлбөр- (гэрээн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор) – 40%;

б) Гэрээний явцын төлбөрийг үе шатны ажлын гүйцэтгэлийн актын дагуу шилжүүлнэ. Ингэхдээ урьдчилгаа төлбөрөөс хувь тэнцүүлэн суутгана.

в) үлдэгдэл ажлын төлбөр-(ажил хүлээлцсэний дараа ажлын 5 хоногийн дотор)-15%.

3.5 Захиалагч нь Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд Гүйцэтгэгчээс гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5 хувийг уг хугацаа дуустал барьцаанд үлдээнэ.

3.6 Захиалагч ажлын үнэ, хөлсийг нэхэмжлэлийн дагуу Гүйцэтгэгчийн Төрийн сангийн 1002 1001 4402 харилцах дансанд шилжүүлгээр төлнэ.

3.7 МТЗ шаардсан тухай бүрт Гүйцэтгэгч нь хийгдэж буй ажлын талаар зохих мэдээлэл, гэрээний хэрэгжилт, тайланг хүргүүлэх ба эдгээр нь ажлын үнэ, хөлс төлөх үндэслэл болно.

3.8 Гүйцэтгэгч ажлыг шаардлага хангасан түвшинд гүйцэтгээгүй тохиолдолд Захиалагч нь зохих түвшинд хүргэх, шаардлага хангах хүртэл дараагийн ажлын хөлс, төлбөрийг saatuuлах эрхтэй.

Дөрөв. Захиалагчийн эрх, үүрэг

4.1. Захиалагч нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлд зааснаас гадна зураг төсөл, төсөв, бусад зайлшгүй шаардлагатай баримт бичгийг Гүйцэтгэгчид шилжүүлэн өгөх, мэдээллээр хангах үүрэгтэй.

4.2. Барилгын ажлын санхүүжилтийг ажлын үе шат бүрт тухайн ажлыг баталгаажуулсны дараа төлнэ.

4.3. Барилгын ажлын явц, түүний чанар, үр дүнд хяналт тавина.

4.4. Гүйцэтгэсэн барилгын ажилд гологдол, согог илэрвэл тухай бүрт арилгуулна.

4.5 Гүйцэтгэгч гэрээний үүргээ удаа дараа биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол алданги ногдуулах, ажлын үр дүнг хүлээлгэн өгөх боломжгүй болсон тохиолдолд үнэ, хөлс төлөхөөс татгалзах, Хууль тогтоомжид заасан үндэслэлээр гэрээг нэг талын санаачилгаар цуцлах эрхтэй.

4.6 Гүйцэтгэгчийн ажил зохих норм, дүрэм, стандартын шаардлага хангагүй тохиолдолд хүлээн авахаас татгалзах, дахин гүйцэтгэхийг шаардах, нөхөн гүйцэхэд гаргасан зардлыг Гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх (төлөх ёстой төлбөрөөс суутган авах) эрхтэй.

4.7 Барилгын ажлыг хүлээн авснаас хойш хуульд зааснаар гомдлын шаардлага тавих эрхтэй.

4.8 Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Тав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

5.1 Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлд зааснаас гадна зураг төсөл, бусад шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг авах, ажил, үүргийг цаг хугацаанд нь мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх, Захиалагчаас тавьсан шаардлагыг биелүүлэх, барилгын угсралтын ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж Захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.

5.2 Гүйцэтгэгч нь гэрээний үнэ, хөлсийг гэрээнд заасны дагуу төлөхийг шаардах, ажил гүйцэтгэхтэй холбогдуулан нэмэлт мэдээлэл авах, тодорхой үндэслэлээр ажлын хугацаа сунгуулах эрхтэй.

5.3. Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажил нь Захиалагчийн баталсан зураг төсөл, норм ба дүрэм зөрчсөн, өөрчлөгдсөн, чанарын шаардлага хангагүй тохиолдолд тухайн шаардлага хангагүй гэрээний зүйлийг дахин үнэ төлбөргүй засч, запруулах, арилгах, өгсөн шаардлага, зааварчилгааг биелүүлэх үүрэгтэй.

5.4 Баталгаат хугацааны дотор чанарын доголдол гарвал өөрийн зардлаар засварлах үүрэгтэй.

5.5 Захиалагчийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдээр гүйцэтгүүлэхийг хориглоно.

5.6 Туслан гүйцэтгэгч ажиллуулсан тохиолдолд түүнтэй гэрээ байгуулах, түүний ажил, үүргийг Захиалагчийн өмнө бүрэн хариуцна.

5.7 Ажил гүйцэтгэх явцад өөрийн ажилтны ХАБЭА байдлыг бүрэн хариуцна.

5.8 Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Зургаа. Талуудын хүлээх хариуцлага

6.1 Гүйцэтгэгч нь барилгын ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй, хүлээлгэн өгөөгүй, хугацааг хэтрүүлсэн, чанарын доголдлыг тогтоосон хугацаанд арилгаагүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй ажлын үнийн дүнгийн 0.5 хувиар тооцож алданги төлнө.

6.2. Захиалагчийн буруугаас барилга угсралтын ажлыг тасалдуулсан тохиолдолд холбогдох зардлыг Захиалагч хариуцна.

6.3 Алданги төлсөн нь Талуудыг гэрээнд заасан үүргээ гүйцэтгэх, учирсан хохирлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

7.1 Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл тухайлбал газар хөдлөлт , үер, гал түймэр, салхи, шуурга, халдварт өвчний тархалт, хорио цээр болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн байгууллагын шийдвэр, оролцоо зэрэг нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

7.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас Захиалагч буюу Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих хугацаанд хийж гүйцэтгээгүй бол шаардлагатай хугацаагаар сунгаж болно.

7.3. Бараа, материал, түүхий эдийн хомсдол, үнийн өсөлт, үйлдвэрлэгч болон бараа нийлүүлэгчийн шийдвэр, хязгаарлалт нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлд хамаarahгүй.

Найм. Маргаан шийдвэрлэх

8.1. Гэрээг биелүүлэхтэй холбогдон Талуудын хооронд үүссэн санал, зөрөлдөөн маргааныг талууд харилцан тохиролцо замаар шийдвэрлэнэ.

8.2. Хэрэв маргаантай асуудлаар Талууд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд уг асуудлыг харьялах шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

Ес. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

9.1. Барилгын ажил гүйцэтгэх явцад барилгын ажил, үнэ, хөлсөөс бусад нөхцөлд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь Талууд харилцан тохиролцож, зөвхөн бичгээр хийгдэж гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

Арав. Гэрээг цуцлах

10.1 Талууд харилцан тохиролцож хууль тогтоомжид заасан үндэслэлээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

Арваннэг. Ажлын стандарт шаардлага, доголдол арилгах, баталгаа

11.1 Барилга байгууламж, төсөв, барилгын материал бүтээгдэхүүн нь Барилгын тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

11.2 Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний хавсралтад заасан ажлын зураг төсөл, төсөв, техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу гүйцэтгэсэн, зохих стандартад нийцсэн ажлын үр дүнг хүлээлгэж өгнө.

11.3 Гүйцэтгэгч нь ажлын үр дүнд Иргэний хуульд заасны дагуу З жилийн баталгаа гаргаж өгнө.

11.4 Талууд ажлыг зохих журмын дагуу гүйцэтгээгүй, доголдол, эвдрэл гэмтэл гарсан, стандартын шаардлага, төрийн эрх бүхий байгууллагын чиглэл, удирдамжийг зөрчиж гүйцэтгэсэн нь ажлын гүйцэтгэлийг хянах явцад болон баталгаат хугацаанд илэрсэн бол уг зөрчлийг үнэ төлбөргүй засварлаж, доголдлыг арилгах үүрэгтэй.

Арванхоёр. Бусад зүйл

12.1 Гэрээ нь Талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэн эсхүл хуульд заасан үндэслэлээр дуусгавар болно.

12.2 Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээ мэдээллийг бусдад бичгэн буюу аман хэлбэрээр задруулах, гэрээнд зааснаас өөр зорилгоор ашиглахыг хориглоно. Энэ заалт нь Гүйцэтгэгчийн төлөөлөгч, бүх ажилтан болон туслан гүйцэтгэгч наарт нэгэн адил хамаарна.

12.3 Гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

12.4 Гэрээг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагч:

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн
Хяналт шалгалтын газрын дарга


М.Амарсайхан
Барилгын инженер

М.Амарсайхан

О.Билгүүн

Харилцах утас: 99098562, 88117447


Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, 13 дугаар хороолол, 1 дүгээр
хороо, UNION BUILDING, А блок, 7
дугаар давхар

Гүйцэтгэгч:

Зэвсэгт хүчиний 110 дугаар ангийн
Ерөнхий инженер, хошууч


Л.Баттулга
Зэвсэгт хүчиний 110 дугаар ангийн
Санхүүгийн албаны дарга, ахлах нягтлан
бодогч, хошууч

Ч.Самданжамц


Харилцах утас: 7069-6049, 92090221
Хаяг: Орхон аймаг, Эрдэнэт хот, Говил
баг

